



МОНГОЛ УЛСЫН  
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 12 сарын 13 өдөр

Дугаар A/72


Улаанбаатар хот

Г Ашигт малтмал, газрын тосны газрын  
үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын  
бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газар /Б.Баатарцогт/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Даваадорж/-т тус тус даалгасугай.
3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Уул уурхайн сайдын 2013 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн “Зохион байгуулалтын ерөнхий бүдүүвч, бүтцийг шинэчлэн батлах тухай” 19 дүгээр, 2015 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн “Үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 110 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ц.ДАШДОРЖ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын  
2016 оны 12 дугаар сарын 13 өдрийн  
172 дугаар тушаалын хавсралт

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
СТРАТЕГИ, БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Оршил

Ашигт малтмал, газрын тосны газрын /цаашид “агентлаг” гэх/ үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр /цаашид “хөтөлбөр” гэх/-ийн зорилго нь Засгийн газар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан ашигт малтмал, газрын тосны салбарын нэгдсэн бодлого, стратегийн төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны стратегийн болон зохион байгуулалтын бүтцийн загварыг тодорхойлоход оршино.

1.2. Үндэслэл

Хөтөлбөрийг боловсруулахдаа Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын 2016 оны 07 дугаар 27-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг тус тус үндэс болгов.

1.3. Хууль тогтоомжийн орчин:

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль
- Төсвийн тухай хууль
- Газрын тухай хууль
- Газрын хэвлэлийн тухай хууль
- Газрын тосны тухай хууль, түүнийг дагалдах журмууд
- Ашигт малтмалын тухай хууль
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Үндэсний аюулгүй байдлын тухай хууль
- Хөрөнгө оруулалтын тухай хууль
- Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль
- Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль
- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль

- Цөмийн энергийн тухай хууль
- Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль
- Технологи дамжуулах тухай хууль
- Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль
- Агаарын бохирдлын тухай хууль
- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
- Төрөөс эрдэс баялагийн салбарт баримтлах бодлого
- Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого
- Төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого
- Өндөр технологийн аж үйлдвэрийн талаар төрөөс баримтлах бодлого
- Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль
- Бусад хууль тогтоомж


#### 1.4. Арга зүй

Энэхүү хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн ерөнхий загвар”-т нийцүүлэн боловсруулсан болно.

1.5. Ашигт малтмал, газрын тосны газрын үүрэг, хариуцлагын ерөнхий хуваарь:


Ашигт малтмал, газрын тосны газар нь геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хууль тогтоомж, бодлого, гэрээ, хэлэлцээр, стратегийн төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэг, хариуцлага хүлээж, ашигт малтмал, газрын тосны асуудлаар хэрэглэгчийг мэдээллээр хангаж ажиллана.

**Ашигт малтмал, газрын тосны газрын үүрэг хариуцлагын  
ерөнхий хуваарь**



## 1.6. Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Ашигт малтмал, газрын тосны газрын стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр, нэн ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг зөв тодорхойлох нь тус газрын үйл ажиллагааны стратегийг үндэслэл сайтай тогтооход чухал ач холбогдолтой юм. Энэ хэрэгцээний эх үүсвэрт дор дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамрагдана:



Ашигт малтмал, газрын тосны газрын стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч, хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн чиг үүрэг, албан хаагчдын ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

Хоёр. Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагааны стратеги

### 2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар:

Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Газрын хэвллийн тухай хууль, Газрын тосны тухай хууль, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, Газрын тосны тухай хуулиуд, тэдгээрийн дагалдах журмууд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын бодлогын удирдамжийг хэрэгжүүлэхэд оршино.

### 2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

Ашигт малтмал, газрын тосны газар нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

- 2.2.1 Нутаг дэвсгэрийн геологи, геофизик, геохими, гидрогоеологи, региональ судалгаа, ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тосны, эрэл, хайгуулын ажил, металлогенийн судалгааг аж ахуйн нэгж, байгууллагуудтай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, улс орны эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах, хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахуйц бус, зангилааг ялган, тэдгээрт төрийн захиргааны төв байгууллагын санал авч, судалгаа хийхийг санал болгох, геологийн судалгааны бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх,
- 2.2.2 Газрын тосны ордуудыг ашиглалтад шилжүүлэх, олборлолтыг нэмэгдүүлэх бодлогын удирдамж, гэрээний хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах,
- 2.2.3 Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах, хэрэглэгчдэд хөнгөн шуурхай, шударга үйлчилгээ үзүүлэх, тус салбарт явуулж буй төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар үндэсний эдийн засгийн хөгжилд газрын тосны салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх
- 2.2.4 Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, Уул уурхайн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээг судалж, хэтийн төлөвийг тодорхойлох, ашигт малтмал, газрын тосыг эдийн засгийн өндөр үр ашигтай, байгаль орчинд сөрөг нелөөлөл багатай техник, технологи ашиглан олборлох, баяжуулах, гүн боловсруулах, борлуулахтай холбогдсон судалгаа хийж дүгнэлт гаргах, санал зөвлөмж боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, ашигт малтмал олборлох, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх
- 2.2.5 Ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор ердийн болон цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл, газрын тосны эрэл, хайгуулын болон гэрээт талбайд холбогдох үйлчилгээ үзүүлэх;
- 2.2.6 Эрдэс баялгийн салбарын мэдээллийн төрөлжсөн, нэгдсэн сан бүрдүүлэх, баяжуулах, боловсруулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах, мэдээллийн сангийн чиглэлээр гадаад орнууд, олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх.

### 2.3. Үйл ажиллагааны эрхэм зорилго

Ашигт малтмал, газрын тосны газрын эрхэм зорилго нь төрөөс геологи, уул уурхай, газрын тосны салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулагчид, хэрэглэгчдэд хөнгөн шуурхай, шударга үйлчилгээ үзүүлэх, тус салбарт явуулж буй төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар үндэсний эдийн засгийн хөгжилд ашигт малтмал, газрын тосны салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхэд оршино.

### 2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт:

Ашигт малтмал, газрын тосны газар нь эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 2.4.1. Төрийн захиргааны удирдлагын манлайлал, хүний нөөцийн удирдлагаар хангах, байгууллагын хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг оновчтой удирдах, тайлагнах;
- 2.4.2. Агентлагийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм, журам, стандарт боловсруулах, батлуулах,

мөрдүүлэхэд эрх зүйн дэмжлэг үзүүлэх, салбарын хэмжээнд байгуулагдах Бүтээгдэхүүн хуваах гэрээ болон бусад гэрээ, хэлэлцээр хийх ажлыг зохион байгуулах, сурталчлах, гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих;

- 2.4.3. Агентлагийн эрхлэх асуудлын хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудлыг эрхлэх, салбарын статистик мэдээллийн сан үүсгэж, удирдлагыг мэдээллээр хангах;
- 2.4.4. Геологийн салбарын хөгжлийн бодлого боловсруулах, бүтээгдэхүүн хуваах гэрээ, эрлийн гэрээ болон бусад гэрээ, хэлэлцээр байгуулахад дэмжлэг үзүүлэн хайгуулын ажлыг нэмэгдүүлж эрдэс баялгийн санг өстөх, геологийн төрөл бүрийн сэдэвчилсэн судалгааны санал боловсруулах;
- 2.4.5. Газрын тосны ордуудыг ашиглалтад шилжүүлэх, олборлолтыг нэмэгдүүлэх бодлогын удирдамж, гэрээний хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах;
- 2.4.6. Газрын тосны бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг тогтвортой, олон эх үүсвэрээс хангах чиглэл баримтлах, санал боловсруулах, байгаль орчинд болон хүний эруул мэндэд сөрөг нөлөөлөл багатай, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, аюулгүй, стандартын шаардлага хангасан газрын тос бүтээгдэхүүний барилга байгууламж, техник технологи, тоног төхөөрөмжөөр үйл ажиллагаа явуулах бодлогыг хэрэгжүүлэх;
- 2.4.7. Уул уурхайн салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэн шаардлагатай мэдээллээр хангах, бодлогын удирдамжийг хэрэгжүүлэх, энэ салбарт хөрөнгө оруулалтын орчинд үнэлэлт, дүгнэлт өгөх, түүнийг сайжруулах санал, судалгаа боловсруулах;
- 2.4.8. Хүнд үйлдвэрийн салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэн шаардлагатай мэдээллээр хангах, бодлогын удирдамжийг хэрэгжүүлэх, энэ салбарт хөрөнгө оруулалтын орчинд үнэлэлт, дүгнэлт өгөх, түүнийг сайжруулах санал, судалгаа боловсруулах, инновацийн идэвхжилтийн судалгааг хийх;
- 2.4.9. Нүүрсний салбарын бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангах, бодлогын удирдамжийг хэрэгжүүлэх, салбарын хэтийн төлөв, стратегийн төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах;
- 2.4.10. Ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор ердийн болон цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл, газрын тосны эрэл, хайгуулын болон гэрээт талбайд холбогдох кадастрын үйлчилгээ үзүүлэх;
- 2.4.11. Эрдэс баялгийн салбарын мэдээллийн төрөлжсөн, нэгдсэн сан бүрдүүлэх, баяжуулах, боловсруулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах, мэдээллийн сангийн чиглэлээр гадаад орнууд, олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- 2.4.12. Газрын тосны бүтээгдэхүүн, шатах ашигт малтмал болон тэдгээрийн бүтээгдэхүүний шинжилгээ, туршилтыг Монгол Улсад мөрдөгдөж буй стандартын дагуу чанарын өндөр түвшинд, хурдан шуурхай гүйцэтгэх, дүгнэлт гаргах, санал зөвлөмж боловсруулах, ашигт малтмалын салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх.

## 2.5. Үйл ажиллагааны гол зорилт

Ашигт малтмал, газрын тосны газрын стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны дараах гол зорилтуудыг дэвшүүлэн ажиллана:

### 2.5.1. Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

- 2.5.1.1 Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах
- 2.5.1.2 Байгууллагын хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг оновчтой төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах ажлыг зохион байгуулах мөн газрын тосны салбарын хөрөнгө оруулалтыг бодитой тогтоож, хяналт тавих
- 2.5.1.3 Хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах
- 2.5.1.4 Газрын тостой холбоотой үйл ажиллагаанаас орох орлогыг төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах
- 2.5.1.5 Агентлагийн эрхлэх асуудлын хүрээнд гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах
- 2.5.1.6 Хайгуулын ажлын тайланг хүлээн авч, хайгуулын ажлын зардлын доод хэмжээг хянан тухайн жилийн е-баланстай тулган баталгаажуулж холбогдох дүгнэлт, тодорхойлолт гаргах, төрийн болон төрийн бус байгууллага, дотоод хэлтсүүдийг мэдээллээр хангах
- 2.5.1.7 Бүтээгдэхүүн хуваах гэрээ, газрын тос болон уламжлалт бус газрын тосны эрлийн гэрээтэй холбоотой хөрөнгө оруулалт, борлуулалт, өртөг зардлын хяналт хийх;
- 2.5.1.8 Гэрээлэгчдийн хөрөнгө оруулалт-өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулах;
- 2.5.1.9 Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа геологийн судалгааны төслүүдийн төсвийн гүйцэтгэлийг хянах.

### 2.5.2. Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

- 2.5.2.1 Агентлагийн даргын шийдвэрийг хууль тогтоомжид нийцүүлэн гаргахад дэмжлэг үзүүлэх, агентлагийн эрхлэх асуудлын хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах;
- 2.5.2.2 Ашигт малтмал, газрын тос, цөмийн энергийн хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, түүний дагалдах дүрэм журмын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавих;
- 2.5.2.3 Агентлагийн дарга /холбогдох нэгжийн удирдлага/-ын гаргасан шийдвэртэй холбоотой хэрэг, маргаанд байгууллагын эрх ашгийг хамгаалан, шүүх, хууль хяналтын бусад байгууллагад үр дүнтэйгээр төлөөлөн оролцох
- 2.5.2.4 Агентлагийн бүтцийн нэгж, албан тушаалтнуудад уул уурхай, салбарын хууль тогтоомжийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх, эрх зүйн мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах.

### 2.5.3. Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

- 2.5.3.1 Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх санал боловсруулах, тайлагнах, хариуцлага тооцох, урамшуулах дотоодын хяналтын тогтолцоог сайжруулж боловсронгуй болгох;
- 2.5.3.2 Салбарын хэмжээнд болон байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилан таниулах, мэдээ мэдээлэл болон статистик, тоон мэдээллийг тодорхой давтамжтайгаар боловсруулан түгээх, сургалт, давтан сургалтыг тодорхой төлөвлөгөөтэйгөөр хэрэгжүүлэх

#### 2.5.4. Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

- 2.5.4.1 Нутаг дэвсгэрийн геологи, гидрогоеологийн зураглал, геофизик, геоэкологийн болон сэдэвчилсэн судалгааг гэрээгээр гүйцэтгүүлэх, хяналт тавих, ашигт малтмалын тархалтын зүй тогтоцыг судалж эрдэс баялгийн нөөцийн үнэлгээ өгөх;
- 2.5.4.2 Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй геологийн судалгааны төслүүдийн төлөвлөгөө, геологийн даалгавар боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, тайланг хүлээн авч хянах, холбогдох дүгнэлт, шийдвэр гаргах замаар геологийн судалгааны ажлыг удирдан чиглүүлэх болон эрх зүйн орчинг боловсронгуй болгох санал зөвлөгөө өгөх;
- 2.5.4.3 Төрөөс тогтоосон талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл сонгон шалгаруулалтаар олгох талбайн геологийн судалгааны үр дүнгийн талаарх материалуудыг бэлтгэх, холбогдох хэлтсийг мэдээллээр хангах;
- 2.5.4.4 Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн геологи-хайгуулын ажлын нөхөн төлбөрийн хэмжээг тогтоож гэрээ байгуулан, улсын төсөвт төвлөрүүлэх;
- 2.5.4.5 Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх, нөөцийг өсгөх ажлыг зохион байгуулах
- 2.5.4.6 Бүтээгдэхүүн хуваах гэрээ, газрын тос болон уламжлалт бус газрын тосны эрлийн гэрээний хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих
- 2.5.4.7 Газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагааны хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлыг хянаж, мэргэжлийн дүгнэлт гаргахад оролцох.

#### 2.5.5. Үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд:

- 2.5.5.1 Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төсөлд техник технологийн шинжилгээ хийж, санал боловсруулах;
- 2.5.5.2 Газрын тосны тухай хууль, стандарт, дүрэм, журам, заавар болон бусад холбогдох хууль тогтоомж, Засгийн газар болон төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах;
- 2.5.5.3 Газрын тосны ордуудыг ашиглах олборлолтын барилга, байгууламж, дэд бүтцийг барьж байгуулах, ордыг ашиглалтад шилжүүлэх ажлыг зохион байгуулах;
- 2.5.5.4 Газрын тосны ордын ашиглалтыг эрчимжүүлэн олборлолтыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх;
- 2.5.5.5 Газрын тосны орд ашиглалтын үйл ажиллагаа болон Монгол Улсын Засгийн газарт ногдох түүхий тосыг хэмжих, хадгалах, тээвэрлэхэд хяналт тавих;
- 2.5.5.6 Газрын тосны олборлолтын үйл ажиллагааны хөрөнгө оруулалт, өртгөөр нөхөгдөх зардлыг хянаж, баталгаажуулахад мэргэжлийн дүгнэлт гаргах;
- 2.5.5.7 Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийг хангуулах, хэрэгжилтэд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх.

#### 2.5.6. Үйл ажиллагааны стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд:

- 2.5.6.1 Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг тогтвортой хангах, импортын эх үүсвэр болон хилийн боомтыг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах;
- 2.5.6.2 Улсын хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүний байнгын нөөцтэй байх зохион байгуулалтын арга хэмжээ авах;

- 2.5.6.3 Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний үнийн хэлбэлзлийн талаар тухай бүр судалгаа явуулах, зөвлөмж боловсруулах, дотоодын жижиглэнгийн үнийг тогтвортой байлгах чиглэл баримтлах;
- 2.5.6.4 Газрын тосны бүтээгдэхүүний импорт, нөөц, үлдэгдэл, жижиглэн борлуулалтын үнэ татвар, хэрэглээ, гадаад зах зээлийн үнийн мэдээллийг тогтмол нэгтгэх, удирдлагыг болон хэрэглэгчийг мэдээллээр хангах, мэдээллийн сан бүрдүүлэх;
- 2.5.6.5 Газрын тосны бүтээгдэхүүнийг импортоо, хадгалах, худалдах үеийн чанар хяналтыг холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран хяналт тавих ажлыг зохион байгуулах, санал боловсруулах, холбогдох стандартын төслийг боловсруулах;
- 2.5.6.6 Газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход агуулахын барилга байгууламж, тоног төхөөрөмжид техникийн дүгнэлт гаргах, бүртгэлийн гэрчилгээ олгох, цуцлах, хадгалах савыг паспортжуулах, агуулахын судалгааг гаргах;
- 2.5.6.7 Газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход ШТС-ын барилга байгууламж, тоног төхөөрөмжид техникийн дүгнэлт гаргах, бүртгэлийн гэрчилгээ олгох, цуцлах, савыг паспортжуулах, агуулахын судалгааг гаргах.

2.5.7. Үйл ажиллагааны стратегийн 7 дугаар зорилтын хүрээнд:

- 2.5.7.1 Уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах, салбарын хөрөнгө оруулалтын орчны талаар дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдад сурталчилах;
- 2.5.7.2 Уул уурхайн үйлдвэрлэлд ашиглаж байгаа техник, технологид үнэлэлт өгөх, технологийн бодлогыг хэрэгжүүлэх;
- 2.5.7.3 Уул уурхайн үйлдвэрлэлээс улс орны нийгэм, эдийн засаг, болон байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөллийг судлах, үнэлэх, дүгнэлт гаргах;
- 2.5.7.4 Уул уурхайн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээг судалж, хэтийн төлөвийг тодорхойлох;
- 2.5.7.5 Уул уурхайн салбарын төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эрх зүйн орчинг сайжруулах арга хэмжээ авах;
- 2.5.7.6 Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн хууль эрх зүйн орчны талаар санал, дүгнэлт гаргах;
- 2.5.7.7 Салбарын хөгжлийн бодлого боловсруулж байгаа төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох бусад байгууллагуудад холбогдох мэдээлэл бэлтгэж өгөх.

2.5.8. Үйл ажиллагааны стратегийн 8 дугаар зорилтын хүрээнд:

- 2.5.8.1. Хүнд үйлдвэрийн салбарт хэрэгжүүлэх дүрэм, журам, стандартыг боловсруулан холбогдох байгууллагаар батлуулах;
- 2.5.8.2. Хүнд үйлдвэрийн салбарт хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, салбарын хөрөнгө оруулалтын орчны талаар дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдад сурталчилах, Хүнд үйлдвэрлэлээс улс орны нийгэм, эдийн засаг, болон байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөллийг үнэлэх, дүгнэлт гаргах;
- 2.5.8.3. Хүнд үйлдвэрлэлд ашиглаж байгаа техник, технологид үнэлэлт өгөх, технологийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх, инновацийг нэвтрүүлэх, нутагшуулах, хөгжүүлэх талаар судалгаа хийж, боловсруулах;

- 2.5.8.4. Зэс, нүүрс, хар ба өнгөт төмөрлөг, газрын тос боловсруулах үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, сурталчилах;
- 2.5.8.5. Салбарын хөгжлийн бодлого боловсруулж байгаа төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох бусад байгууллагуудад холбогдох мэдээлэл бэлтгэж өгөх;
- 2.5.8.6. Хүнд үйлдвэрийн салбарын стандарт, дүрэм, журам, заавар болон бусад холбогдох хууль тогтоомж, Засгийн газар болон төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах.

2.5.9. Үйл ажиллагааны стратегийн 9 дүгээр зорилтын хүрээнд:

- 2.5.9.1 Нүүрсний салбарын бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангах, бодлогын удирдамжийг хэрэгжүүлэх, салбарын хэтийн төлөв, стратегийн төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах
- 2.5.9.2 Нүүрсний уурхайнуудын техник технологийн түвшинд үнэлэлт, дүгнэлт өгөх, техник эдийн засгийн үндэслэл, уулын ажлын тайлан, төлөвлөгөөг хүлээн авч, бүртгэх, нүүрсний нөөцийн хөдөлгөөнийг хийх, байгаль орчин, Хөдөлмөрийн аюулгүй байдлын хууль, дүрэм зааврыг хэрэгжүүлэх, нүүрсийг баяжуулах замаар нүүрсний чанарын зэрэглэлийг дээшлүүлэх технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- 2.5.9.3 Нүүрсний салбараас улс орны нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг үнэлэх, дүгнэлт гаргах, экспорт, зах зээл, нүүрсний борлуулалт, хангамжийн судалгааг гаргаж, хөрөнгө оруулалтын орчинд үнэлэлт дүгнэлт өгөх, мэдээллээр хангах

2.5.10. Үйл ажиллагааны стратегийн 10 дугаар зорилтын хүрээнд:

- 2.5.10.1 Ердийн ашигт малтмал болон цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авч хянан шийдвэрлэх;
- 2.5.10.2 Тусгай зөвшөөрөл сунгуулах, шилжүүлэх, барьцаалсан тусгай зөвшөөрөл бүртгэх, өргөдлийг хүлээн авч хянан бүртгэх;
- 2.5.10.3 Тусгай зөвшөөрөл цуцлах, тусгай зөвшөөрлөөр олгосон талбайг бүхэлд нь болон хэсэгчлэн буцааж хүлээн авах өргөдлийг хянан шийдвэрлэх;
- 2.5.10.4 Тусгай зөвшөөрөлтэй холбоотой статистик, мэдээ мэдээлэл боловсруулах нийтэд мэдээлэх;
- 2.5.10.5 Тусгай зөвшөөрлийн талбайн хилийн маргааныг шийдвэрлэх;
- 2.5.10.6 Геологи, уул уурхайн болон газрын тосны эрлийн талбай, хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн кадастр хөтлөх;
- 2.5.10.7 Газрын тосны эрлийн ажил явуулах талбайн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлүүлэх;
- 2.5.10.8 Сонгон шалгаруулалтаар газрын тосны хайгуулын талбай болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох талбайн мэдээллийг гаргах, сонгон шалгаруулалтанд оролцохоор өргөдөл гаргасан хуулийн этгээдийн өргөдлийг хүлээн авах.

2.5.11. Үйл ажиллагааны стратегийн 11 дүгээр зорилтын хүрээнд:

- 2.5.11.1 Геологи, уул уурхай, газрын тос, эрдэс баялгийн бүх төрлийн ажлын үр дүнгийн тайлан, үйл ажиллагааны бүх төрлийн мэдээллийг хүлээн авах, боловсруулалт хийж төрөлжсөн болон нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, баяжуулах;

- 2.5.11.2 Мэдээллийн төрөлжсөн, нэгдсэн цахим сан бүрдүүлэх, боловсруулах, баяжуулах болон хэрэглэгчийг мэдээллээр түргэн шуурхай, найдвартай хангах зорилгоор орчин үеийн, олон улсын жишигт хүрэхүйц мэдээллийн технологи, программ хангамж, найдвартай сүлжээг бий болгож байнга сайжруулах;
- 2.5.11.3 Архивын сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт, ашиглалт, архив, албан хэрэг хөтлөлтийн ажлын зохион байгуулалтыг зохих хууль, тогтоол, журмын хүрээнд гүйцэтгэх зорилго бүхий архивын үйлчилгээг боловсронгуй болгох, зохион байгуулах;
- 2.5.11.4 Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд гүйцэтгэх геологи, хайгуулын судалгааны ажилд сонгон шалгаруулалтаар шинээр олгох талбайд хийгдсэн геологийн судалгааны үр дүнгийн төрөлжсөн болон нэгдсэн мэдээллээр холбогдох хэлтсүүдийг хангах;
- 2.5.11.5 Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээн дэх эрдэс баялгийн чадавхийг тодорхойлох зорилго бүхий нөөцийн хөдөлгөөний нэгдсэн мэдээллийн санг зохих журмын дагуу бүрдүүлэх, баяжуулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах;

#### 2.5.12. Үйл ажиллагааны стратегийн 12 дугаар зорилтын хүрээнд:

- 2.5.12.1 Шатах ашигт малтмалын химиин найрлага, бүтэц, физик, механик, дулааны шинж чанарыг тодорхойлох шинжилгээ, туршилт гүйцэтгэх;
- 2.5.12.2 Шатах ашигт малтмалыг боловсруулж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн гарган авах, байгаль орчинд хор нөлөө багатай ашиглах туршилт, судалгаа гүйцэтгэхэд төрийн захирагааны төв байгууллагад дэмжлэг үзүүлэх;
- 2.5.12.3 Экспортын нүурс, нүурсэн бүтээгдэхүүний чанарын түвшинг тодорхойлж, хяналт тавих, Гаалийн байгууллагыг мэдээллээр хангах, экспортын нүурсний чанарыг дээшлүүлэх замаар эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- 2.5.12.4 Уул уурхайн орчны хөрс, усны бохирдлыг тодорхойлох шинжилгээ, туршилт гүйцэтгэх;
- 2.5.12.5 Лабораторид хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний захиалагчийн үүрэг гүйцэтгэж, техникийн хяналт тавих
- 2.5.12.6 Газрын тосны бүтээгдэхүүнд шинжилгээ хийх
- 2.5.12.7 Газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын тогтолцоог боловсронгуй болгох.
- 2.5.12.8 Газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох, хадгалах, худалдах үеийн чанар хяналтыг холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран хяналт тавих ажлыг зохион байгуулах, санал боловсруулах, холбогдох стандартын төслийг боловсруулах

#### 2.6. Үйл ажиллагааны зорилт

Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагааны гол зорилт бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилт (чиг үүрэг)-ыг ажилтан, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод тусган хэрэгжүүлнэ.

#### 2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар

Агентлагийн үйл ажиллагаа /бизнес/-ны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлсон байна.

# АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА(БИЗНЕС)-НЫ СТРАТЕГИ ЗАГВАР

Зорилго	Үндсэн үйл ажиллагааны стратеги	Үйл ажиллагааны гол зорилт
<p>Ашигт малтмал, газрын тосны газрын эрхэм зорилго нь төреөс геологи, уул уурхай, газрын тосны салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулагчид, хэрэглэгчдэд хөнгөн шуурхай, шударга үйлчилгээ үзүүлэх, тус салбарт явуулж буй териин бодлогыг хэрэгжүүлэх замаар үндэсний эдийн засгийн хөгжилд ашигт малтмал, газрын тосны салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхэд оршино.</p>	<p><b>Төрийн захиргааны удирдлагын манлайлал, хүний нөөцийн удирдлагаар хангах, байгууллагын хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг оновчтой удирдах, тайлагнах</b></p> <p><b>Агентлагийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм, журам, стандарт боловсруулах, батлуулах, мөрдүүлэхэд эрх зүйн дэмжлэг үзүүлэх, салбарын хэмжээнд байгуулгадах Бүтээгдэхүүн хуваах гэрээ болон бусад гэрээ, хэлэлцээр хийх ажлыг зохион байгуулах, сурталчлах, гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих</b></p> <p><b>Агентлагийн эрхлэх асуудлын хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудлыг эрхлэх, салбарын статистик мэдээллийн сан үүсгэж, удирдлагыг мэдээллээр хангах</b></p> <p><b>Геологийн салбарын хөгжлийн бодлого боловсруулах, бүтээгдэхүүн хуваах гэрээ, эрлийн гэрээ болон бусад гэрээ, хэлэлцээр байгуулахад дэмжлэг үзүүлэн хайгуульын ажлыг нэмэгдүүлж эрдэс баяягийн санг ёсгех, геологийн төрөл бүрийн сэдвичилсэн судалгааны санал боловсруулах</b></p> <p><b>Газрын тосны ордуудыг ашиглалтад шилжүүлэх, олборлолтыг нэмэгдүүлэх бодлогын удирдамж, гэрээний хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах</b></p> <p><b>Газрын тосны бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг тогтвортой, олон эх үүсвэрээс хангах чиглэл баримтлах, санал боловсруулах, байгаль орчинд болон хүний эрүүл мэндэд серег нөлөөлөл багатай, дэвшилтэй техник, технологи нэвтрүүлах, аюулгүй, стандартын шаардлага хангасан газрын тос бүтээгдэхүүний барилга байгууламж, техник технологи, тоног төхөөрөмжөөр үйл ажиллагаа явуулах бодлогыг хэрэгжүүлэх</b></p>	<p><b>Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Газрын тостой холбоотой үйл ажиллагаанаас орох орлогыг төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах</li> <li>- Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах</li> <li>- Хайгуулын ажлын тайланг хүлээн авч, хайгуулын ажлын зардлын доод хэмжээг хянан тухайн жилийн е-бланстай тулган баталгаажуулах</li> <li>- Гэрээлэгчийн хөрөнгө оруулалт, өртөг-нөхөгдөх зардлыг хянан баталгаажуулах</li> <li>- УТХ-өөр гүйцэтгэх бүй ГСА-ын төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, төслүүдийн төсвийн норм, нормативыг хянах</li> </ul> <p><b>Агентлагийн даргын шийдвэрийг хууль тогтоомжид нийцүүлэн гаргахад дэмжлаг үзүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах;</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Ашигт малтмал, газрын тос, цамийн энергийн хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтийг холбоотой үйл ажиллагаанд хяналт тавих;</li> <li>- Агентлагийн дарга /холбогдох нэгжийн удирдлагын гаргасан шийдвэртэй холбоотой хөрөг, маргааны байгууллагын эрх ашигийг хамгаалан, шүүх, хууль хяналтын бусад байгууллагад үр дүнтэгээр төлөвлөн орцлох</li> <li>- Агентлагийн бүтцийн нэгж, албан тушаалтнуудад уул уурхай, салбарын хууль тогтоомжийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх, эрх зүйн мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах</li> </ul> <p><b>Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр нөлөө, үр ашигийг дээшшуулэх санал боловсруулах, тайланах, хариуцлага тооцож, урамшуулах дотоодын хяналтын тогтолцоог сайжруулж боловсронгуй болгох;</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Салбарын хэмжээнд болон байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилгааны тайнуулах, мэдээлэл болон статистик, тоон мэдээллийг тодорхой давтамжтайгаар боловсруулан түгээх, сургалт, давтан сургалтыг тодорхой төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлэх</li> </ul> <p><b>Нутаг дэвсгэрийн геологи, гидрогеологийн зураглал, геофизик, геоколонийн болон сэдэвчилсэн судалгааг гэрээгээр гүйцэтгүүлэх, хяналт тавих, ашигт малтмалын тархалтын зүй тогтооцыг судалж эрдэс баяялгийн нөөцийн үнэлгээг ехэх;</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- УТХ-өөр гүйцэтгэх бүй геологийн судалгааны төслүүдийн хэрэгжилтийг хангуулах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох санал зөвлөхөөг ехэх;</li> <li>- Төреөс тогтооцон талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл сонгон шалгаруулалтгаар олгох талбайн геологийн судалгааны үр дүнгийн талаарх материалиудыг бэлтгэх, холбогдох хэлтэйн мэдээллээр хангах;</li> <li>- Улсын төсийн хөрөнгөөр хийдгээн геологи-хайгуулын ажлын нөхөн төлбөрхийн хэмжээг тогтоож гэрээ байгуулан, улсын төсөвт төвлөрүүлэх,</li> <li>- Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх, нөөцийг ёсгех ажлыг зохион байгуулах</li> <li>- Бутээгдэхүүн хуваах гэрээ, газрын тос болон уламжлалт бус газрын тосны эрэлний хэрэгжилтийг хангуулах</li> <li>- Газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагааны хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлыг хянаж, дүгнэлт гаргахад орцлох</li> </ul> <p><b>Газрын тосны бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг тогтвортой, олон эх үүсвэрээс хангах чиглэл баримтлах, санал боловсруулах, байгаль орчинд болон хүний эрүүл мэндэд серег нөлөөлөл багатай, дэвшилтэй техник, технологи нэвтрүүлах, аюулгүй, стандартын шаардлага хангасан газрын тос бүтээгдэхүүний барилга байгууламж, техник технологи, тоног төхөөрөмжөөр үйл ажиллагаа явуулах бодлогыг хэрэгжүүлэх</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төсөнд техник технологийн шинжилгээ хийж, санал боловсруулах;</li> <li>- Газрын тосны тухай хууль, стандарт, дүрэм, журам, заавар болон бусад холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн биеэлэтийг хангах;</li> <li>- Газрын тосны ордуудыг ашиглаж олборлолтын барилга, байгууламж, дэд бүтцийн барьж байгуулах, ашиглалтад шилжүүлэх ажлыг гүйцэтгэх;</li> <li>- Газрын тосны ордын ашиглалтад шилжүүлэх олборлолтыг нэмэгдүүлах бодлогыг хэрэгжүүлах;</li> <li>- Газрын тосны орд ашиглалтын үйл ажиллагааг болон Монгол Улсын Засгийн газарт ногдох тухай тосыг хэмжих, хадгалах, тэзвэрлэхэд хяналт тавих;</li> <li>- Газрын тосны олборлолтын үйл ажиллагааны хөрөнгө оруулалт, өртөөр нөхөгдөх зардлыг хянаж, баталгаажуулаад мэргэжлийн дүгнэлт гаргах;</li> <li>- Бутээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийг хангуулах, хэрэгжилтэд хяналт тавих дэмжлэг үзүүлэх.</li> </ul> <p><b>Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг тогтвортой хангах, импортын эх үүсвэр болон хийлийн боомтыг нэмэгдүүлэх;</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Улсын хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүний байгуулын нөөцтэй байх зохион байгуулалтын арга хэмжээ авах;</li> <li>- Газрын тосын хижиглэгээнд үнүүдийг тогтвортой байгуулалтад чиглэх;</li> <li>- Газрын тосын бүтээгдэхүүний импорт, хөдөлгөөн, хадгалах, худалдаа чөнөөн чанар хяналтын байгуулах, стандартын төсөл боловсруулах;</li> <li>- Газрын тосын бүтээгдэхүүний бөвийн болон хижиглэгээнд худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход техникийн дүгнэлт гаргах, судалгаа гаргах;</li> </ul>

Уул уурхайн салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэн шаардлагатай мэдээллээр хангах, бодлогын удирдамжийг хэрэгжүүлэх, энэ салбарт хөрөнгө оруулалтын орчинд үнэлэлт, дүгнэлт өгөх, түүнийг сайжруулах санал, судалгаа боловсруулах

- Уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, салбарын хөрөнгө оруулалтын орчны талаар сурталчилах;
- Уул уурхайн үйлдвэрлэлд ашиглаж байгаа техник, технологид үнэлэлт өгөх, технологийн бодлогыг хэрэгжүүлэх;
- Уул уурхайн үйлдвэрлэлээс улс орны нийгэм, эдийн засаг, болон байгаль орчинд үзүүлэх судлах, унэлэх, дүгнэлт гаргах;
- Уул уурхайн салбарын тесэл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эрх зүйн орчинг сайжруулах арга хэмжээ авах;
- Бичиглүүртэй үйл ажиллагааг эрхлагчдийн хууль эрх зүйн орчны талаар санал, дүгнэлт гаргах;
- Мэдээллээр хангах

Хүнд үйлдвэрийн салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэн шаардлагатай мэдээллээр хангах, бодлогын удирдамжийг хэрэгжүүлэх, энэ салбарт хөрөнгө оруулалтын орчинд үнэлэлт, дүгнэлт өгөх, түүнийг сайжруулах санал, судалгаа боловсруулах, инновацийн идэвхжилтийн судалгааг хийх

- Хүнд үйлдвэрийн салбарт хэрэгжүүлэх дүрэм, журам, стандартыг боловсруулан холбогдуулж байгууллагаар батлуулах;
- Хүнд үйлдвэрийн салбарт хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, салбарын хөрөнгө оруулалтын орчны талаар дотоод, гадаадын хөрөнгө оруулалтад сурталчилах;
- Хүнд үйлдвэрлэлээс улс орны нийгэм, эдийн засаг, болон байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөллийг үнэлэх, дүгнэлт гаргах;
- Хүнд үйлдвэрлэлээс ашиглаж байгаа техник, технологид үнэлэлт өгөх, инновацийн нэвтрүүлэх, нутагшуулах;
- Зэс, нүүрс, хар ба өнгөт төмөрлөг, газрын тос боловсруулах үйлдвэрийн теслийг хэрэгжүүлэхад дэмжлэг үзүүлэх, сурталчилах;
- Салбарын хөгжлийн бодлого боловсруулах байгаа териин захираганы төв байгууллага болон холбогдох бусад байгууллагуудад холбогдох мэдээлэл болтгаж өгөх;
- Хүнд үйлдвэрийн салбарын стандарт, дүрэм, журам, заавар болон бусад холбогдох хууль тогтоомж, Засгийн газар болон териин захираганы төв байгууллагаас гаргасан шийдвэрийн биенэлтийг хангах

Ашигт малтмал, газрын тосны газрын эрхэм зорилго нь төрөөс геологи, уул уурхай, газрын тосны салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулагчид, хэрэглэгчдэд хөнгөн шуурхай, шударга үйлчилгээ үзүүлэх, тус салбарт явуулж буй төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар үндэсний эдийн засгийн хөгжилд ашигт малтмал, газрын тосны салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхэд оршино.

Нүүрсний салбарын бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангах, бодлогын удирдамжийг хэрэгжүүлэх, салбарын хэтийн төлөв, стратегийн төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах

- Нүүрсний салбарын бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангах, бодлогын удирдамжийг хэрэгжүүлэх, салбарын хэтийн төлөв, стратегийн төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах
- Нүүрсний уурхайнуудын техник технологийн түвшинд үнэлэлт, дүгнэлт өгөх, техникийн засгийн үндэслэл, уулсын ажлын тайлан, төвлөгөөг хулзэн авч, бүртгэх, нүүрсний нөөцийн хөдөлгөөнийг хийх, байгаль орчин, Хөдөлмөрийн аюулгүй байдлын хууль, дүрэм зааврыг хэрэгжүүлэх, нүүрсийг болжуулсан замар нүүрсний чанарын зэрэглэлийг дэшишүүлэх технологийн нэвтрүүлэхад дэмжлэг үзүүлэх
- Нүүрсний салбарас улс орны нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг үнэлэх, дүгнэлт гаргах, экспорт, зах зээл, нүүрсний борлуулалт, хангамжийн судалгааг гаргах, хөрөнгө оруулалтын орчинд үнэлэлт дүгнэлт өгөх, мэдээллээр хангах

Ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор ердийн болон цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл, газрын тосны эрэл, хайгуулын болон гэрээт талбайд холбогдох кадастрын үйлчилгээ үзүүлэх

- Ердийн ашигт малтмал болон цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авч хянан шийдвэрлэх;
- Тусгай зөвшөөрөл сунгуулах, шилжүүлэх, барьцаалсан тусгай зөвшөөрөл бүртгэх, өргөдлийг хүлээн бүртгэх;
- Тусгай зөвшөөрөл цуцлах, тусгай зөвшөөрөр олгосон талбайг бүхэлд нь болон хасгасчилан буцаах хулзэн авах өргөдлийг хянан шийдвэрлэх;
- Тусгай зөвшөөрөлтэй холбогдох статистик, мэдээ мэдээлэл боловсруулах нийтд мэдээлэх;
- Тусгай зөвшөөрөлийн талбайн хийлийн маргааныг шийдвэрлэх;
- Геологи, уул уурхай, газрын тос, эрдэс баялагийн бүх төрлийн ажлын үр дүнгийн тайлан, үйл ажиллагааны бүх төрлийн мэдээллийг хүлээн авах, боловсруулалт хийж сан бүрдүүлж, хөтөх, баяжуулах;
- Хэрэглэгчийн мэдээллээс түргэн шүүрхийг нийдэвэртэй хангах зорилгоор орчин үеийн, олон улсын жишит хүрэкүйц мэдээллийн технологи, программын хангамж, найдвартай сүжэээс бий болгож байгаа сайжруулах;
- Архивын сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт, ашиглалт, архив, албан хэрэг хөтөлгөөний зохион байгуулах, архивын үйлчилгээ болгарсон болгож;
- Сонгон шалгаруулалтаар газрын тосны хайгуулын талбай болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох талбайн мэдээллийг гаргах, сонгон шалгаруулалтанд оролцохоор өргөдөл гаргасан хуулийн этгээдийн өргөдлийг хүлээн авах

Эрдэс баялагийн салбарын мэдээллийн төрөлжсөн, нэгдсэн сан бүрдүүлэх, баяжуулах, боловсруулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах, мэдээллийн сангийн чиглэлээр гадаад орнууд, олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх

- Геологи, уул уурхай, газрын тос, эрдэс баялагийн бүх төрлийн ажлын үр дүнгийн тайлан, үйл ажиллагааны бүх төрлийн мэдээллийг хүлээн авах, боловсруулалт хийж сан бүрдүүлж, хөтөх, баяжуулах;
- Хэрэглэгчийн мэдээллээс түргэн шүүрхийг найдвартай хангах зорилгоор орчин үеийн, олон улсын жишит хүрэкүйц мэдээллийн технологи, программын хангамж, найдвартай сүжэээс бий болгож байгаа сайжруuлах;
- Архивын сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт, ашиглалт, архив, албан хэрэг хөтөлгөөний зохион байгуулах, архивын үйлчилгээ болгарсон болгож;
- Сонгон шалгаруулалтаар газрын тосны хайгуулын талбай хийгдсэн геологийн судалгааны үр дүнгийн төрөлжсөн болон нэгдсэн мэдээллээр холбогдох холтцуудийн хангах;
- Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд эрдэс баялагийн чадавхийг тодорхойлох зорилго бүхий нөөцийн хөдөлгөөний нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах

Газрын тосны бүтээгдэхүүн, шатах ашигт малтмал болон тэдгээрийн бүтээгдэхүүний шинжилгээ, туршилтыг Монгол улсад мөрдөгдэх буй стандартын дагуу чанарын өндөр түвшинд, хурдан шуурхай гүйцэтгэх, дүгнэлт гаргах, санал зөвлөмж боловсруулах, ашигт малтмалын салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх

- Шатах ашигт малтмалын химийн найрлага, бүтэц, физик, механик, дулааны шинж чанарын тодорхойлох шинжилгээ, туршилт гүйцэтгэх;
- Шатах ашигт малтмалын боловсруулж нэмүү өргөт шинжэсэн бүтээгдэхүүн гаргах, байгаль орчинд хор нөлөө багатай ашиглах туршилт, судалгаа гүйцэтгэх;
- Экспортын нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүний чанарын түвшинг тодорхойлох, хангалт тавих, Галийн байгууллагыг мэдээллээр хангах;
- Уул уурхайн орчны хөрс, усны бохирдлыг тодорхойлох шинжилгээ, туршилт гүйцэтгэх;
- Лабораторийн хэрэгжүүлэлт төсөл, арга хэмжээний захиалагчийн үүрэг гүйцэтгэх, техникийн хяналт тавих;
- Газрын тосны бүтээгдэхүүний импортох, хадгалах, худалдах үеийн чанар хяналтыг холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран хяналт тавих ажлыг зохион байгуулах, санал боловсруулах, холбогдох стандартын теслийг боловсруулах

Гурав. Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн чиг үүрэг.

### 3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоог боловсруулахад баримтлах зарчим

Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоог боловсруулахад дор дурдсан зарчмыг баримтлав. Үүнд:

- 3.1.1 Ашигт малтмал, газрын тосны газрын ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь тус газрын үйл ажиллагааны стратегийн зорилттой нийцсэн байх;
- 3.1.2 Бүтцийн нэгжүүдийн нэр нь тэдгээрийн үйл ажиллагааны стратегийг тусгасан байх;
- 3.1.3 Бүтцийн хувьд энгийн байх;
- 3.1.4 Бүтцийн нэгжүүдийг аль болох хялбар удирдах, үйл ажиллагааг нь хянах боломжтой байх;
- 3.1.5 Улс төржихгүй байх зарчим /тухайн агентлагийн албан хаагч нь эрхэлсэн сайд, Засгийн газар, бусад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчдэд төвийг сахисан өндөр мэргэшлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, улс төрийн нөлөөлөлд автахгүй байх/;
- 3.1.6 Бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхийг бүрэн дүүрэн илрүүлэхэд чиглэсэн, хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх;
- 3.1.7 Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх;
- 3.1.8 Хангалттай чадавхи, бодитой үйл ажиллагаа явуулах (үйл ажиллагааны ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхиа бүрэн илрүүлэхэд чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх);
- 3.1.9 Агентлагийн удирдлага, албан хаагчид мэргэшсэн, шуурхай бүтээлч, чирэгдэлгүй байх.

### 3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар.

Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагааны стратеги болон бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримталсан зарчимд үндэслэн тус газар нь зохион байгуулалтын бүтцийн дор дурдсан нэгжүүдтэй байна. Үүнд:

1. Төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж
2. Хууль, эрх зүйн асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж
3. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, статистикийн асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж
4. Геологи хайгуулын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж
5. Газрын тосны ашиглалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж (орон нутагт төлөөлөгчидтэй)
6. Газрын тосны бүтээгдэхүүний асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж (орон нутагт төлөөлөгчидтэй)
7. Уул уурхайн үйлдвэрлэл техник, технологийн асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж
8. Хүнд үйлдвэрлэл, техник технологийн асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж

9. Нуурсний судалгааны асуудал эрхэлсэн зохион байгуулалтын нэгж;
10. Кадастрын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын нэгж;
11. Эрдэс баялгийн мэдээлэлийн технологийн асуудал эрхэлсэн зохион байгуулалтын нэгж
12. Газрын тос, шатах ашигт малтмалын шинжилгээ, туршилтын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын нэгж;

### 3.3. Зохион байгуулалтын бүтэц

Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг үндэслэн дор дурдсан зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүргийг тодорхойлж байна. Үүнд:

#### 3.3.1 Төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, байгууллагын санхүүгийн асуудлыг шийдвэрлэх үндсэн үүргийг хүлээж, байгууллагын үйл ажиллагаанд удирдлагын тэргүүний арга барил, туршлагыг нэвтрүүлэх, хүний нөөцийн удирдлага, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, салбарын боловсон хүчнийг бэлтгэх, санхүү бүртгэлийн үйл ажиллагаа, аж ахуй, нийтлэг үйлчилгээг хүн бүрт хүргэж үйлчлэх, гэрээлэгчдийн хөрөнгө оруулалт-өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулах, Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй геологийн судалгааны төслүүдийн төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, төслүүдийн төсвийн норм, нормативыг хянах, байгууллагын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх, нэгжүүдийн ажлын уялдаа холбоог сайжруулах, ажлаа тайлагнах, хариуцлага тооцох, үр дүнг үнэлэн дүгнэх, урамшуулах тогтолцоог боловсронгуй болгох, гадаад харилцаа, хамтын ажиллагаа, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан нэгжийн үйл ажиллагаа нь Ашигт малтмал, газрын тосны газрын дарга болон нэгжийн удирдлагуудад шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд эрх зүйн болон дотоод үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө, дэмжлэгээр хангах, нэгжүүдийн хоорондын ажлын уялдаа холбоог хангах, удирдлагын тэргүүний арга барил, туршлагыг нэвтрүүлэх, байгууллагын санхүү, бүртгэлийг хөтлөн, санхүүгийн тайлан бэлтгэх, ажилтнуудыг чадваржуулах, мэргэжүүлэх, дадал, туршлага эзэмшүүлэх замаар хөгжүүлэх, тэдний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Ашигт малтмал, газрын тосны газрын дарга, газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, тэдгээрийн ажилтнууд байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, дэд сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яам, Төрийн сан, Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, аж ахуйн нэгж, иргэд байна.

#### 3.3.2 Хууль, эрх зүйн асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийг хууль, эрх зүйд нийцүүлэх, хууль тогтоомж, ашигт малтмал, газрын тос, цөмийн энерги болон бусад салбарын хууль тогтоомжоор зохицуулагдах үйл ажиллагааны дүрэм, журам, стандарт боловсруулах, батлуулах, мөрдүүлэхэд эрх зүйн дэмжлэг үзүүлэх, газрын тосны салбарын хэмжээнд байгуулагдах Бүтээгдэхүүн хуваах гэрээ болон бусад гэрээ, хэлэлцээр хийх ажлыг зохион байгуулах, сурталчлах, хяналт тавих үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Ашигт малтмал, газрын тосны газрын удирдлагууд, газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, албан хаагчид байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээний хэрэглэгч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Уул уурхай, хүнд үйлдварийн яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчид, аж ахуйн нэгж, иргэд, шүүх, хууль хяналтын байгууллага байна.

### 3.3.3 Хяналт-шинжилгээ, үнэлгээ, статистикийн асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дотоод хяналтыг хэрэгжүүлэх болон статистик мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, сургалт сурталчилгаа явуулах үндсэн үүргийг хүлээж, Ашигт малтмал, газрын тосны газрын ажилтнуудын цаг ашиглалтыг сайжруулах, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, дотоод хяналт шалгалтын тогтолцоог буй болгох, удирдлагын шийдвэр, бодлого журмын хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, аппаратын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх, салбарын холбогдолтой мэдээ, мэдээлэл, статистик тоон үзүүлэлтүүдийг нэгтгэн боловсруулах, удирдах дээд байгууллага, иргэдийг шаардлагатай мэдээллээр хангах, салбарын үйл ажиллагааг сурталчилан таниулах, сургалт, давтан сургалтын ажлыг зохион байгуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, статистикийн асуудал хариуцсан нэгжийн үйл ажиллагаа нь Ашигт малтмал, газрын тосны газрын даргад болон газрын нэгжүүдийн шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө, дэмжлэгээр хангах, ажилтнуудын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Ашигт малтмал, газрын тосны газрын дарга, орлогч дарга, газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, тэдгээрийн ажилтнууд байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, дэд сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд, төрийн болон төрийн бус байгууллагууд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, аж ахуйн нэгж, иргэд байна.

### 3.3.4 Геологи хайгуулын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд нутаг дэвсгэрийн геологи, геофизик, геохими, геоэкологи, гидрогеологийн региональ судалгаа, ашигт малтмал, газрын тосны

эрлийн ажил, металлогенийн судалгааг Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бодлогын удирдамжийн дагуу гүйцэтгэж, улс орны эрдэс баялгийн чадавхийг тодорхойлох ажлыг зохион байгуулах, хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахуйц хүдрийн бүс, зангилааг ялган, тэдгээрт судалгаа хийхийг санал болгох, геологи, ашигт малтмал, газрын тосны судалгааны бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, улсын хэмжээний ашигт малтмалын мэдээллийн нэгдсэн санг тогтмол баяжуулж хэрэглэгчдийг мэдээллээр хангах, улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй геологийн судалгааны төслүүдийн геологийн судалгааны даалгавар боловсруулах, геологийн судалгааны ажлыг удирдан чиглүүлэх, зөвлөлгөө өгөх, эрх зүйн орчны судалгаа хийх, сонгон шалгаруулалтаар зарласан талбайг сонгох үндэспэл болох геологийн судалгааны үр дунгийн талаарх материалуудыг бэлтгэж төрийн захиргааны төв байгууллагад танилцуулах, хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл болон сонгон шалгаруулалтанд ирүүлсэн баримт бичигт хавсаргасан хайгуулын ажлын төсөлд дүгнэлт гаргах, төслийн гүйцэтгэлд хяналт тавих, хайгуулын ажлын төлөвлөгөө, тайланг хянаж хүлээн авах, хайгуулын ажлын зардлын доод хэмжээг хянан баталгаажуулах, хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хүлээн авч холбогдох дүгнэлт, шийдвэрийг гаргах ажлыг зохион байгуулах, үндсэн үүрэгтэй байна.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Ашигт малтмал, газрын тосны газрын дарга, орлогч дарга, геологийн судалгааны ажил гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд байх ба шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, дэд сайд, УУХҮЯ-ны газар, хэлтсүүд, Сангийн яам, "Үндэсний гео мэдээллийн сан" хөтөлбөрийг хэрэгжүүлэгч төслүүд, геологи, эрдэс баялгийн судалгааны ажил эрхэлдэг их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, бусад яамд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагууд, нутгийн захиргааны байгууллагууд, иргэд, аж ахуй нэгж, олон улсын байгууллага байна.

3.3.5 Газрын тосны ашиглалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд газрын тосны ордуудыг ашиглах олборлолтын ил байгууламж, дэд бүтцийг барьж байгуулах, ордыг ашиглалтад шилжүүлэх ажлыг зохион байгуулах, газрын тосны ордын ашиглалтыг эрчимжүүлэн олборлолтыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх, олборлож, борлуулах түүхий тосыг хэмжих, хадгалах, тээвэрлэхэд хяналт тавих, газрын тосны олборлолтын үйл ажиллагааны хөрөнгө оруулалт, өртгөөр нөхөгдөх зардлыг хянаж, баталгаажуулахад мэргэжлийн дүгнэлт гаргах, Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийг хангуулах, хэрэгжилтэд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх, газрын тосны олборлолт, ашиглалтын үйл ажиллагаатай холбогдсон тайлан, материалыг судалж, санал дүгнэлт гаргах, цахим мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний шууд хэрэглэгч нь Ашигт малтмал, газрын тосны газрын удирдлагууд байх ба шууд бус хэрэглэгч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, холбогдох бусад яам, агентлаг, газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчид, хөрөнгө оруулагчид, орон нутгийн захиргаа, их, дээд сургуулиуд, эрдэм шинжилгээ, хил гааль, хяналт шалгалт, хэвлэл мэдээллийн болон бусад байгууллагууд байна.

### 3.3.6 Газрын тосны бүтээгдэхүүний асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагааны стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн талаар төрөөс баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээг “Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль” болон бусад хуулийн хүрээнд зохион байгуулах, газрын тосны бүтээгдэхүүнээр тогтвортой хангахад дэмжлэг үзүүлэх, импортын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, улсын хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүний байнгын нөөцтэй байх зохион байгуулалтын арга хэмжээ авах, газрын тосны бүтээгдэхүүний импорт, нөөц, үлдэгдэл, жижиглэн борлуулалтын үнэ татвар, гадаад зах зээлийн үнийн мэдээллийг тогтмол хийх, байгаль орчинд болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл багатай, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, аюулгүй, стандартын шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүний барилга байгууламж, техник технологи, тоног төхөөрөмжөөр үйл ажиллагаа явуулах бодлогыг хэрэгжүүлэх удирдлагыг болон хэрэглэгчийг мэдээллээр хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Ашигт малтмал, газрын тосны газрын удирдлагууд байх ба шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээний хэрэглэгч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон импортлогч, хангамж, борлуулалттай холбогдсон үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж байгууллагууд, бусад яамд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагууд, нутгийн захиргааны байгууллагууд, хил, гаалийн байгууллага, олон улсын байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагууд байна.

### 3.3.7. Уул уурхайн үйлдвэрлэл техник, технологийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 7 дугаар зорилтын хүрээнд уул уурхайн асуудал эрхэлсэн тэрийн захиргааны төв байгууллагад уул уурхайн салбарын хөгжлийн бодлого боловсруулахад нь дэмжлэг үзүүлэн шаардлагатай мэдээллээр хангах, бодлогын удирдамжийг нь хэрэгжүүлэх, энэ салбарт хөрөнгө оруулалтын орчинд үнэлэлт, дүгнэлт өгөх, түүнийг сайжруулах санал, судалгаа боловсруулах чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Энэ хүрээнд уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах, салбарын хөрөнгө оруулалтын орчны талаар дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдад сурталчилах, уул уурхайн үйлдвэрлэлд ашиглаж байгаа техник, технологид үнэлэлт өгөх, технологийн бодлогыг хэрэгжүүлэх, уул уурхайн үйлдвэрлэлээс улс орны нийгэм, эдийн засаг, болон байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөллийг судлах, үнэлэх, дүгнэлт гаргах, уул уурхайн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээг судалж, хэтийн төлөвийг тодорхойлох, уул уурхайн салбарт төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн хууль эрх зүйн орчны талаар санал, дүгнэлт гаргах, салбарын хөгжлийн бодлого боловсруулахад шаардлагатай судалгаа, мэдээллээр хангах асуудал хамаарна.

Үндсэн хэрэглэгч нь Ашигт малтмал, газрын тосны газрын дарга, орлогч дарга байх ба шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, ашигт малтмал олборлох, боловсруулах ажил эрхэлдэг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгжүүд, уул уурхайн

чиглэлээр шинжилгээ, судалгааны ажил эрхэлдэг их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд, бусад яамд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагууд, нутгийн захиргааны байгууллагууд, гадаад орон, олон улсын байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагууд байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газрын дотоод бүтцийн нэгжүүд байна.

3.3.8. Хүнд үйлдвэрлэл, техник технологийн асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 8 дугаар зорилтын хүрээнд Хүнд үйлдвэрийн салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэн шаардлагатай мэдээллээр хангах, бодлогын удирдамжийг хэрэгжүүлэх, энэ салбарын хөрөнгө оруулалтын орчинд үнэлэлт, дүгнэлт өгөх, түүнийг сайжруулах санал, судалгаа боловсруулах, инновациын идэвхижилтийн судалгааг хийх чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Энэ хүрээнд хүнд үйлдвэрийн техник, технологийн норм, норматив, стандарт болон журам, дүрэм, зааврын төсөл боловсруулан холбогдох байгууллагаар батлуулах, хүнд үйлдвэрлэлд ашиглаж байгаа техник, технологид үнэлэлт өгөх, технологийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх, хүнд үйлдвэрийн салбарт хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, салбарын хөрөнгө оруулалтын орчны талаар дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдад сурталчилах, хүнд үйлдвэрлэлээс улс орны нийгэм, эдийн засаг, болон байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөллийг үнэлэх, дүгнэлт гаргах, хүнд үйлдвэрийн техник, технологи, инновацийг нэвтрүүлэх, нутагшуулах, хөгжүүлэх талаар судалгаа хийж, боловсруулах, дотоодын боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүнийг ашиглах импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх талаар судалгаа хийж дүгнэлт гаргах, уул уурхай, газрын тосны боловсруулах үйлдвэрийн талаарх судалгаа, техник, технологийн судалгаа хийж, санал боловсруулах зэрэг асуудал хамаарна.

Нэгжийн үндсэн хэрэглэгч нь Ашигт малтмал, газрын тосны газрын дарга, Орлогч дарга байх ба шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, ашигт малтмал олборлох, боловсруулах үйл ажиллагаа эрхэлдэг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгжүүд, хүнд үйлдвэрийн чиглэлээр шинжилгээ, судалгааны ажил эрхэлдэг их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд, Засгийн газрын яамд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагууд, нутгийн захиргааны байгууллагууд, гадаад орон, олон улсын байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагууд байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газрын дотоод бүтцийн нэгжүүд байна.

3.3.9. Нүүрсний судалгааны асуудал эрхэлсэн зохион байгуулалтын нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 9 дүгээр зорилтын хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад нүүрсний салбарын бодлого боловсруулахад нь дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангах, бодлогын удирдамжийг хэрэгжүүлэх, салбарын хэтийн төлөв, стратегийн төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Энэ хүрээнд нүүрсний салбарын бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангах, бодлогын удирдамжийг хэрэгжүүлэх, салбарын хэтийн төлөв, стратегийн төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, нүүрсний уурхайнуудын техник технологийн түвшинд үнэлэлт, дүгнэлт өгөх, техник эдийн засгийн үндэслэл, уулын ажлын тайлан, төлөвлөгөөг хүлээн авч, бүртгэх, нүүрсний нөөцийн хөдөлгөөнийг хийх, хайгуулын нөхөн төлбөрийг гаргуулж улсын төсөвт төвлөрүүлэх, Байгаль орчин, Хөдөлмөрийн аюулгүй байдлын хууль, дүрэм зааврыг хэрэгжүүлэх, нүүрсийг баяжуулах замаар нүүрсний чанарын зэрэглэлийг дээшлүүлэх технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, нүүрсний салбараас улс орны нийгэм, эдийн засагт үзүүлэх нэлөөллийг үнэлэх, дүгнэлт гаргах, экспорт, зах зээл, нүүрсний борлуулалт, хангамжийн судалгааг гаргаж, хөрөнгө оруулалтын орчинд үнэлэлт дүгнэлт өгөх, мэдээллээр хангах зэрэг асуудал хамаарна.

Нэгжийн үндсэн хэрэглэгч нь Ашигт малтмал, газрын тосны газрын дарга, Орлогч дарга байх ба шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, нүүрс олборлох, боловсруулах үйл ажиллагаа эрхэлдэг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгжүүд, нүүрс судалгааны чиглэлээр шинжилгээ, судалгааны ажил эрхэлдэг их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд, Засгийн газрын яамд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагууд, нутгийн захиргааны байгууллагууд, гадаад орон, олон улсын байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагууд байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газрын дотоод бүтцийн нэгжүүд байна.

### 3.3.10. Кадастрын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын нэгж, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 10 дугаар зорилтын хүрээнд Ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэн, ердийн болон цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл, газрын тосны эрэл, хайгуулын болон гэрээт талбайд холбогдох кадастрын үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Энэ хүрээнд ердийн ашигт малтмал болон цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авч хянан шийдвэрлэх, тусгай зөвшөөрөл сунгуулах, шилжүүлэх, барьцаалсан тусгай зөвшөөрөл бүртгэх, өргөдлийг хүлээн авч хянан бүртгэх, тусгай зөвшөөрөл цуцлах, тусгай зөвшөөрлөөр олгосон талбайг бүхэлд нь болон хэсэгчлэн буцааж хүлээн авах өргөдлийг хянан шийдвэрлэх, тусгай зөвшөөрөлтэй холбоотой статистик, мэдээ мэдээлэл боловсруулах нийтэд мэдээлэх, тусгай зөвшөөрлийн талбайн хилийн маргааныг шийдвэрлэх, геологи, уул уурхайн болон газрын тосны эрлийн талбай, хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн кадастр хөтлөх, газрын тосны эрлийн ажил явуулах талбайн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлүүлэх, Сонгон шалгаруулалтаар газрын тосны хайгуулын талбай болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох талбайн мэдээллийг гаргах, сонгон шалгаруулалтанд оролцохоор өргөдөл гаргасан хуулийн этгээдийн өргөдлийг хүлээн авах зэрэг асуудал хамаарна.

Нэгжийн үндсэн хэрэглэгч нь Ашигт малтмал, газрын тосны газрын дарга, Орлогч дарга байх ба шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд, гэрээлэгч компаниуд, бусад яамд, Засгийн газрын

тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагууд, нутгийн захиргааны байгууллагууд, хэвлэл мэдээллийн байгууллагууд байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түвшний Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газрын дотоод бүтцийн нэгжүүд байна.

3.3.11. Эрдэс баялгийн мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн зохион байгуулалтын нэгж, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 11 дүгээр зорилтын хүрээнд Эрдэс баялгийн салбарын мэдээллийн төрөлжсөн, нэгдсэн сан бүрдүүлэх, баяжуулах, боловсруулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах, мэдээллийн сангийн чиглэлээр гадаад орнууд, олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Энэ хүрээнд геологи, уул уурхай, газрын тос, эрдэс баялгийн бүх төрөл, шатны ажлын үр дүнгийн тайлан, үйл ажиллагааны бүх төрлийн мэдээллийг хүлээн авах, боловсруулалт хийж төрөлжсөн болон нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, баяжуулах, мэдээллийн төрөлжсөн, нэгдсэн цахим сан бүрдүүлэх, боловсруулах, баяжуулах болон хэрэглэгчийг мэдээллээр түргэн шуурхай, найдвартай хангах зорилгоор орчин үеийн, олон улсын жишигт хүрэхүйц мэдээллийн технологи, программ хангамж, найдвартай сүлжээг бий болгож байнга сайжруулах, Архивын сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт, ашиглалт, архив, албан хэрэг хөтлөлтийн ажлын зохион байгуулалтыг зохих хууль, тогтоол, журмын хүрээнд гүйцэтгэх зорилго бүхий архивын үйлчилгээг боловсронгуй болгох, зохион байгуулах, Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд гүйцэтгэх геологи, хайгуулын судалгааны ажилд сонгон шалгаруулалтаар шинээр олгох талбайд хийгдсэн геологийн судалгааны үр дүнгийн төрөлжсөн болон нэгдсэн мэдээллээр холбогдох хэлтсүүдийг хангах, Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээн дэх эрдэс баялгийн чадавхийг тодорхойлох зорилго бүхий нөөцийн хөдөлгөөний нэгдсэн мэдээллийн санг зохих журмын дагуу бүрдүүлэх, баяжуулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах асуудал хамаарна.

Нэгжийн үндсэн хэрэглэгч нь Ашигт малтмал, газрын тосны газрын дарга, Орлогч дарга байх ба шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд, гэрээлэгч компаниуд, сонирхогч иргэд, аж ахуйн нэгж байгууллага, бусад яамд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагууд, нутгийн захиргааны байгууллагууд байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түвшний Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газрын дотоод бүтцийн нэгжүүд байна.

3.3.12. Газрын тос, шатах ашигт малтмалын шинжилгээ туршилтын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын нэгж, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 12 дугаар зорилтын хүрээнд газрын тосны бүтээгдэхүүн, шатах ашигт малтмал болон тэдгээрийн бүтээгдэхүүний шинжилгээ, туршилтыг Монгол улсад мөрдөгдөж буй стандартын дагуу чанарын өндөр түвшинд, хурдан шуурхай гүйцэтгэх, дүгнэлт гаргах, санал зөвлөмж боловсруулах, ашигт малтмалын салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Энэ хүрээнд шатах ашигт малтмалын химийн найрлага, бүтэц, физик, механик, дулааны шинж чанарыг тодорхойлох шинжилгээ, туршилт гүйцэтгэх, шатах ашигт

малтмалыг боловсруулж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн гарган авах, байгаль орчинд хор нөлөө багатай ашиглах туршилт, судалгаа гүйцэтгэхэд төрийн захиргааны төв байгууллагад дэмжлэг үзүүлэх, экспортын нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүний чанарын түвшинг тодорхойлж, хяналт тавих, Гаалийн байгууллагыг мэдээллээр хангах, экспортын нүүрсний чанарыг дээшлүүлэх замаар эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, уул уурхайн орчны хөрс, усны бохирдлыг тодорхойлох шинжилгээ, туршилт гүйцэтгэх, лабораториид хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний захиалагчийн үүрэг гүйцэтгэж, техникийн хяналт тавих, газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох, хадгалах, худалдах үеийн чанар хяналтыг холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран хяналт тавих ажлыг зохион байгуулах, санал боловсруулах, холбогдох стандартын төслийг боловсруулах асуудал хамаарна.

Нэгжийн үндсэн хэрэглэгч нь Ашигт малтмал, газрын тосны газрын дарга, орлогч дарга байх ба шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд, гэрээлэгч компаниуд, иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газрын дотоод бүтцийн нэгжүүд байна.

#### Дөрөв. Үйл ажиллагааны ерөнхий дүн

1. Үйл ажиллагааны стратеги тодорхой болсноор хийх ажлын чиглэл, хамрах хүрээ, дараалал тодорхой болж, үр өгөөж дээшилнэ.
2. АМГТГ-ын ажилтнуудын ажлын чиг үүрэг тодорхой болж, өөрийгөө дайчлах, үр өгөөжтэй ажиллах боломж бүрдэнэ.

~ooOoo~